| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12601000.00 | 12601000.00 | - | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,601,000.00 | 12,601,000.00 | - | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23101100.00 | 22337600.00 | 763,500.00 | 96.69 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,101,100.00 | 22,337,600.00 | 763,500.00 | 96.69 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,560,200.00 | 19,796,700.00 | 763,500.00 | 96.29 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,540,900.00 | 2,540,900.00 | - | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 756,025,700.00 | 752,024,665.00 | 4,001,035.00 | 99.47 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 714,102,100.00 | 710,138,531.00 | 3,963,569.00 | 99.44 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 714,102,100.00 | 710,138,531.00 | 3,963,569.00 | 99.44 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 41,923,600.00 | 41,886,134.00 | 37,466.00 | 99.91 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 41,923,600.00 | 41,886,134.00 | 37,466.00 | 99.91 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 52 | 52 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 3 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28 | 28 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18 | 18 | - | 100.00 |

/төгрөгөөр/

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **33,288,672.00** | **33,430,477.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **33,288,672.00** | **33,430,477.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10000000.00 | 4,488,751.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10000000.00 | 4,488,751.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10000000.00 | 4,488,751.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23288672.00 | 28941726.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23288672.00 | 28,941,726.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14727072.00 | 24,318,456.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8561600.00 | 4,623,270.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 23288672.00 | 33430477.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23288672.00 | 33,430,477.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23288672.00 | 33,430,477.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 79 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Насантогтох, нягтлан бодогч Б.Ганболд хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

### 3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу нийгмийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь "Эх орныхоо болон төрөлх нутгийнхаа үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлсэн шинжлэх ухааны мэдлэг боловсролтой, түүнийгээ хэрэглээ болгох чадвартай иргэн төлөвшүүлэх" зорилгыг дэвшүүлэн, суурь боловсролын үйлчилгээг хүргэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь Монголын соёлын урлагийн үнэт өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлах, орчин үеийн уран бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах соёлын бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2020-2021 оны хичээлийн жилд 51 орон тоотой, нийт 503 сурагч суралцсанаас насан туршийн боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр 5, бага, дунд бүлэгт өдрөөр 498 суралцагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд боловсруулсан “Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 857,409.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,574.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,001.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,890.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,515.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 128,850.2 | 114,131.3 | (14,718.9) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 9,950.0 | - | (9,950.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 118,900.2 | 114,131.3 | (4,768.9) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,029,009.4 | 1,010,213.1 | (18,796.3) |
| Үндсэн хөрөнгө | 1,273,482.3 | 1,284,251.3 | 10,769.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (244,472.9) | (274,038.3) | (29,565.4) |
| **Нийт хөрөнгө** | 1,157,859.6 | 1,124,344.4 | (33,515.2) |
| Өр төлбөр | 73.4 | 50.0 | (23.4) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,157,786.2 | 1,124,294.4 | (33,491.8) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,157,859.6 | 1,124,344.4 | (33,515.2) |

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Авлагын дансны эхний үлдэгдэл 9,950.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийн дансанд ухаалаг самбар орлого авснаар барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 114,131.3 мянган төгрөг болж 4,768,9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 85,863.2 мянган төгрөгийн хүнс аж ахуйн материал, аймгийн Засаг даргын Тамгын газар, БСУГ, сумын Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 4,654.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, 81,365.8 мянган



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгийн хөрөнгийг зарцуулж, байгууллагын даргын 2021.11.08-ны өдрийн “Эд хөрөнгө бараа материал актлах, устгах тухай” А/23 дугаартай тушаалаар 13,921.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,284,251.3 мянган төгрөг болж 10,769.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 30,280.0 мянга, авлагыг бууруулж орлого авсан 9,950.0 мянга, аймгийн Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 5,605.0 мянга, Дэлхийн зөн ОУБ-аас нийлүүлсэн 6,264.2 мянга, БСУГ-аас олгосон 2,168.7 мянга, нийт 54,267.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, тайлант онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 137 дугаар тогтоолоор 43,498.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,124,294.4 мянган төгрөг болж 33,491.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 33,491.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 843,252.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 178,098.8 мянган төгрөгөөр бууруулж 665,153.6 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 5 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 756,025.7 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 756,025.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 756,025.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 752,024.7 мянган төгрөгийг зарцуулж 3,963.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 752,024.7 мянган төгрөг буюу 99.47 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 654.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 37.5 мянга, хангамж бараа материалын зардал 500.0 мянга, нормативд зардал 2,045.6 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



055 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 33,430.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 24,318.4 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 4,623.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4,488.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 841,549.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 15,860.7 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 807,660.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 779,063.7 мянган төгрөгийн 142 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл*



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | 2 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 94 | 2 | |
| | Нийт | 27 | 151 | 142 | 7 | 2 |

*Эх сурвалж:Шилэн дансны нэгдсэн системээс*

**3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

Тайлант онд 756,025.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 752,024.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 33,013.4 мянган төгрөгөөс 10 хувь болох 3,301.3 мянган төгрөг хэмнэхээс 2,545.6 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 40,923.6 мянган төгрөгөөр баталж 40,886.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 8,184.7 мянган төгрөг хэмнэхээс 37.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

**3.9**.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

**3.**10 **ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 34,743.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчилд 2 зөвлөмж, 1 санхүүгийн тайлангийн залруулга, 2 албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилтийг Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021.06.14-ны өдрийн 30 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

байхгүй

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 48,080.7 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 50.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 48,030.7 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 6 зөвлөмж хүргүүллээ.

**4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 50.0 мянган төгрөгийг буруу илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5.”Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд Нийгмийн даатгалын хэлтэст өгөх өглөгөөр 50.0 мянган төгрөгийг тусгуулж тайланг залруулав.

## 4.2 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

1. Түлш халаалтын зардлаас худалдан авсан нүүрсний шатахууны зардал болох 2,979.5 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шатахууны зарцуулалтыг гаргахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулалт дахин гаргахгүй байх.

2. Интернет, шуудан холбоо, лиценз, усны шинжилгээ, аудитын төлбөр, бусад зардлын 5,310.3 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн харилцахын данснаас авлага өглөгийн хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын Өглөгийн бүртгэл 4.60 дахь заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" Өглөгийн бүртгэл 4.60 дахь заалтыг мөрдөж ажиллах, алдааг дахин давтахгүй байх.

3. Үйлчлэгч ажилтай С.Мөнхөө нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно" гэж заасаны дагуу 8,182.2 мянган төгрөгийн тэтгэмж авсан байхад байгууллагын дарга 2021.09.02-ны өдрийн Б/22 дугаартай тушаал гаргаж цалингийн зардлаас нэг сартай тэнцэх 520.0 мянган төгрөгийн тэтгэмж төсвөөс нэмж олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны "Эдийн засгийн ангилал батлах тухай" 55 дугаар тушаалыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Цаашид өндөр настны тэтгэвэрт гарч байгаа ажилчдад төсвөөс давхардуулан тэтгэмж олгодог явдлыг таслан зогсоох.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. Цалин, НДШ-ийн тохируулах бичилтийг сар бүр буруу хийснээс жилийн эцэст 2,477.2 төгрөгийг үр дүнгийн тайланд буруу илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2."давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг",14.2.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Санхүүгийн тайланд тохируулах бичилтийг анхан шатны баримтыг үндэслэн зөв илэрхийлж байх.

5. Тус байгууллага нь 2021 онд нийт 807,660.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 779,063.7 мянган төгрөгийн 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 28,596.4 мянган төгрөгийн 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

6. Тайлант онд улсын төсвөөс 756,025.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 752,024.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 3,963.6 мянган төгрөг буюу төсвийн 0.5 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 40,923.6 мянган төгрөгөөр баталж 40,886.1 мянган төгрөгийг зарцуулж, нийт 8,184.7 мянган төгрөг хэмнэхээс 37.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 8,147.2 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн too | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян. төгрөгөөр/



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 5 | 11,337.0 | 1 | 50.0 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 11,287.0 |
| | **Дүн** | **5** | 11,337.0 | 1 | 50.0 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 11,287.0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн данс | 1 | 28,596.4 | | | | | | | 1 | 28,596.4 |
| 2 | ЗГ-ын 43 дугаар тогтоол | 1 | 8,147.3 | | | | | | | 1 | 8,147.3 |
| | **Дүн** | **2** | **36,743.7** | | | | | | | **2** | **36,743.7** |
| | **НИЙТ ДҮН** | **7** | **48,080.7** | 1 | 50.0 | | | | | **6** | **48,030.7** |

oOo



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ